**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 01 сарын 09 өдөр Дугаар Б/01 Дуурсах

Ажлын үр дүнгээр цалин нэмэх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 72.3, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Алба хаагчийн ажлыг үнэлэх" /код 111/-ын 111.4.2, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр зөвлөлийн хуралдааны шийдвэрээр "Шинэ жил" нэгдсэн арга хэмжээний хүрээнд идэвх зүтгэл гарган, үр бүтээлтэй ажилласан 3 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн хэмжээг 1 /нэг/ сар 20 /хорь/ хувь, 10 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн хэмжээг 1 /нэг/ сар 10 /арав/ хувиар нэмж олгосугай.

2. Ажлын үр дүнгээр цалин нэмэх алба хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх нэр бүхий алба хаагчдын цалинг заасан хувь, хэмжээгээр нэмж олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190001

Цагдаагийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 08-ний өдрийн Б/01 дүгээр тушаалын хавсралт

АЛБА ХААГЧДЫН 2019 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ЦАЛИН НЭМЭХ ТУХАЙ

| № | д/д | Овог, нэр | Албан тушаал, цол |
|---|---|---|---|
| | | **1 сар 20 хувь нэмж олгох алба хаагчдын нэрс** | |
| 1 | 1 | Гүнсэнхоролын Алтанхуяг | Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч |
| 2 | 2 | Аварзэдийн Отгонбаяр | Эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлагч |
| 3 | 3 | Энхбаярын Төмөрчөдөр | Эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч |
| | | **1 сар 10 хувь нэмж олгох алба хаагчдын нэрс** | |
| 4 | 4 | Галбадрахын Алтанбагана | Эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч |
| 5 | 5 | Баатарын Пүрэвсүрэн | Аж ахуйн ажилтан, цагдаагийн дэслэгч |
| 6 | 6 | Цэрэнгийн Пүрэвдорж | Хүрээмарал сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч |
| 7 | 7 | Нэргүйн Отгонбаяр | Мөрдөгч, цагдаагийн дэслэгч |
| 8 | 8 | Мөнхөөгийн Бямбадорж | Хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч |
| 9 | 9 | Жаргалын Доржбат | Хүрээмарал сум дахь хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч |
| 10 | 10 | Мягмарсүрэнгийн Галбадрах | Цагдаа-зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч |
| 11 | 11 | Дашцэрэнгийн Насанжаргал | Цагдаа /нохой хөтлөгч/, цагдаагийн ахлагч |
| 12 | 12 | Энхбатын Эрдэнэбаатар | Эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч |
| 13 | 13 | Цэрэндоржийн Мөнх-Эрдэнэ | Цагдаа-жолооч, цагдаагийн дэд ахлагч |

_______000______

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 01 сарын 09 өдөр Дугаар Б/02 Дуурсах

Зарим алба хаагчдыг албан тушаалд
шилжүүлэн ажиллуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах” /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”, 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Алба хаагчийг шилжүүлэн ажиллуулах” журам /код 908/-ын 908.2.2 дахь хэсгийн “б”, “в”, Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2.17-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын зайлшгүй шаардлага болон алба хаагчдаас гаргасан хүсэлт, ар гэрийн байдлыг нь харгалзан цагдаагийн дэд ахлагч Батболдын Өсөхбаярыг Жаргалант сум дахь цагдаагийн үүрэгт ажлаас 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс тасалбар болгон чөлөөлж, энэ оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс Богд сум дахь Сум дундын цагдаагийн тасагт цагдаагаар, цагдаагийн дэд ахлагч Элбэгсайханы Даваацэрэнг Богд сум дахь цагдаагийн үүрэгт ажлаас 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс тасалбар болгон чөлөөлж, энэ оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс Жаргалант сум дахь Сум дундын цагдаагийн тасагт цагдаагийн албан тушаалд тус тус шилжүүлэн томилсугай.

2. Дээрх алба хаагчдын ажлыг ажлын 3 хоногт багтаан хүлээлцүүлж ажиллахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн хошууч Б.Мөнгөнтулга/, хүний нөөцийн санд болон хувийн хэрэгт мэдээллийн баяжилт хөдөлгөөн хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-т үүрэг болгосугай.

3. Дээрх нэр бүхий алба хаагчийн цалинг хэвээр тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.



20190007

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 09 өдөр Дугаар Б/03 Дуурсах

Б.Бадамсэрээжид, Г.Шинэбаяр нарыг албанаас халж, цагдаагийн цол хураах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.3 дахь хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.5, 82 дугээр зүйлийн 82.1.1 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан "Цагдаагийн бага, дунд, ахлах цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх журам"-ын 5.2-ын 5.2.1, 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Байгууллагын даргын тушаал гаргах" /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г", 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан "Сахилгын шийтгэл ногдуулах" /код 914/-ын 914.3.3, 914.3.4, "Албанаас чөлөөлөх, халах" /код 911/-ын 911.6.1 дэх хэсэг, байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журмын 3.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын даргын 2019 оны 01 дүгээр зөвлөлийн хурлын шийдвэрээр Цагдаагийн ерөнхий газрын дэд даргаас 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 3/07 дугаартай албан бичгийн дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны А/129 дүгээр тушаалаар батлагдсан "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 2.4.6 дахь хэсэг, "Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн Эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Билэгмаагийн Бадамсэрээжид, багийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Ганбаатарын Шинэбаяр нарыг 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөр тасалбар болгон албанаас халах сахилгын шийтгэл ногдуулж, "цагдаагийн дэд ахлагч" цолыг хураасугай.

2. Б.Бадамсэрээжид, Г.Шинэбаяр нарын ээлжийн амралтын тооцоог зохих журмын дагуу тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д, албаны үнэмлэх, энгэрийн тэмдэгийн тооцоо хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-т, үнэт цаас, дүрэмт хувцас, бусад холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч, /цагдаагийн дэслэгч

Б.Даваацэрэн/, аж ахуйн ажилтан /цагдаагийн дэслэгч Б.Пүрэвсүрэн/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 10 өдөр Дугаар Б/04 Дуурсах

Зарим алба хаагчдыг албан тушаалд шилжүүлэн ажиллуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах” /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”, 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Алба хаагчийг шилжүүлэн ажиллуулах” журам /код 908/-ын 908.2.2 дахь хэсгийн “б”, “в”, Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2.17-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын зайлшгүй шаардлага болон алба хаагчдаас гаргасан хүсэлт, ар гэрийн байдлыг нь харгалзан цагдаагийн ахлах ахлагч Мягмарсүрэнгийн Бат-Эрдэнийг Заг сум дахь цагдаагийн үүрэгт ажлаас 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс тасалбар болгон чөлөөлж, энэ оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс Баян-Өндөр сум дахь цагдаагаар, цагдаагийн ахлах ахлагч Жаргалын Доржбатыг Хүрээмарал сум дахь цагдаагийн үүрэгт ажлаас 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс тасалбар болгон чөлөөлж, энэ оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс Заг сум дахь цагдаагаар, цагдаагийн дэд ахлагч Батжаргалын Отгоннаранг Захиргааны удирдлагын тасгийн цагдаа-жолоочийн үүрэгт ажлаас 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс тасалбар болгон чөлөөлж, энэ оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс Эрүүлжүүлэх саатуулах байрны жижүүрийн цагдаагийн албан тушаалд тус тус шилжүүлэн томилсугай.

2. Дээрх алба хаагчдын ажлыг ажлын 3 хоногт багтаан хүлээлцүүлж ажиллахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн хошууч Б.Мөнгөнтулга/, хүний нөөцийн санд болон хувийн хэрэгт мэдээллийн баяжилт хөдөлгөөн хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-т үүрэг болгосугай.

3. Дээрх нэр бүхий алба хаагчийн цалинг хэвээр тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.



20190013

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 14 өдөр Дугаар Б/05 Дуурсах

Олон нийтийн цагдаагаар
томилох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 63.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм”-ийн 2.3, 2.8, 3.1, 3.3, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн төв төрийн бус байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, ашигийг хамгаалах нөхцөл, бололцоогоор хангах, сонсгол хэл ярианы бэрхшээлтэй иргэд видео дуудлага болон мессэжээр яаралтай дуудлага өгөх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор олон нийтийн цагдаагаар ажиллах хүсэлт гаргасан Уранчимэгийн Тэмүүжинг 1 дугаар багийн олон нийтийн цагдаагаар энэ оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс томилж, хөдөлмөрийн гэрээ байгуулсугай.

2. Олон нийтийн цагдаагаар шинээр томилогдсон У.Тэмүүжинг сурган дадлагажуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, сонсгол хэл ярианы бэрхшээлтэй иргэд видео дуудлага болон мессэжээр яаралтай дуудлага өгөх нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр жижүүрийн шуурхай албанд ажиллуулахыг Шуурхай удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Э.Алтангэрэл/-д үүрэг болгосугай.

3. Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр /-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190015

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 01 сарын 16 өдөр Дугаар Б/06 Дуурсах

Ажилд томилж, дадлагажуулагч багш томилон, цалинг тогтоох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоолын 8 дугаар хавсралт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох" журам /код 924/, "Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх" /код 900/ журмын 900.3.4-ийн "а", "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэх" /код 944/, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Байгууллагын даргын тушаал гаргах" /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн 2019 оны Ш-2019/06 дугаар зөвшөөрлийн дагуу цагдаагийн дэд ахлагч Жаргалсайханы Цэвээндоржийг энэ оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс тус газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн цагдаагийн албан тушаал /ажлын байр/-д томилсугай.

2. Цагдаагийн дэд ахлагч Ж.Цэвээндоржийн дадлагажуулагч багшаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн хошууч Б.Мөнгөнтулга/-ыг томилсугай.

3. Шинээр томилогдсон алба хаагчийг ажил албанд нь богино хугацаанд сургаж, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, мэргэжлийн алдаа дутагдал гаргах, гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, мэргэжлийн чиг баримжаатай болгох чиглэлээр удирдамж, төлөвлөгөө боловсруулан 6 сарын хугацаанд сурган дадлагажуулж, явц үр дүнгийн талаар илтгэх хуудсаар танилцуулахыг дадлагажуулагч багш Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн хошууч Б.Мөнгөнтулга/-д даалгасугай.



2019 17

4. Шинээр томилогдсон алба хаагчид холбогдох хууль эрх зүйн акт, албан тушаалын заавар, эрх, үүрэг, ажлын байрны тодорхойлолттой танилцуулан, албаны баталгаа гаргуулахыг дадлагажих багшид, хүний нөөцийн санд болон хувийн хэрэгт мэдээллийн баяжилт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-т үүрэг болгосугай.

5. Цагдаагийн дэд ахлагч Ж.Цэвээндоржийн сарын үндсэн цалинг ТТ-7-ийн 1 дүгээр шатлалаар буюу 510107 /таван зуун арван мянга нэг зуун долоо/ төгрөгөөр тогтоож, цолны нэмэгдлийг 25, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг 25 хувиар, тооцон бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

6. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 01 сарын 17 өдөр Дугаар Б/07 Дуурсах

Б.Нэргүйн хөдөлмөрийн гэрээг цуцлах
тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Байгууллагын даргын тушаал гаргах" /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын цагаар ажлын байр нь дээрээ архидан согтуурсан Бямбасүрэнгийн Нэргүйн хөдөлмөрийн гэрээг 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс цуцалсугай.

2. Б.Нэргүйн ажилласан хоногийн цалинг зохих журмын дагуу тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190019

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 01 сарын 17 өдөр Дугаар Б/08 Дуурсах

Б.Үзэхбаяртай хөдөлмөрийн гэрээ байгуулж, галчаар
түр ажиллуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Байгууллагын даргын тушаал гаргах" /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газарт галчаар ажиллахаар хүсэлт гаргасан Бямбаагийн Үзэхбаярын 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн гэрээ байгуулж, галчаар түр ажиллуулсугай.

2. Б.Үзэхбаяртай хөдөлмөрийн гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/, аж ахуйн ажилтан /цагдаагийн дэслэгч Б.Пүрэвсүрэн/ нарт даалгасугай.

3. Б.Үзэхбаяр цалинг ТҮ-2-ын 1 дүгээр шатлал буюу 419382 /дөрвөн зуун арван есөн мянга гурван зуун наян хоёр/ төгрөгөөр тооцож, нэмэлт санхүүжилтээс олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190021

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 01 сарын 17 өдөр Дугаар Б/09 Дуурсах

Ажилд томилж, дадлагажуулагч
багш томилон, цалинг тогтоох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоолын 8 дугаар хавсралт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох" журам /код 924/, "Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх" /код 900/ журмын 900.3.4-ийн "а", "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэх" /код 944/, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Байгууллагын даргын тушаал гаргах" /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн 2019 оны Ш-2019/07 дугаар зөвшөөрлийн дагуу цагдаагийн дэд ахлагч Батжаргалын Ёндонтүвшинг энэ оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс тус газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн цагдаагийн албан тушаал /ажлын байр/-д томилсугай.

2. Цагдаагийн дэд ахлагч Б.Ёндонтүвшингийн дадлагажуулагч багшаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, /цагдаагийн хошууч Б.Мөнгөнтулга/-ыг томилсугай.

3. Шинээр томилогдсон алба хаагчийг ажил албанд нь богино хугацаанд сургаж, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, мэргэжлийн алдаа дутагдал гаргах, гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, мэргэжлийн чиг баримжаатай болгох чиглэлээр удирдамж, төлөвлөгөө боловсруулан 6 сарын хугацаанд сурган дадлагажуулж, явц үр дүнгийн талаар илтгэх хуудсаар танилцуулахыг дадлагажуулагч багш Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, /цагдаагийн хошууч Б.Мөнгөнтулга/-т даалгасугай.



20190023

4. Шинээр томилогдсон алба хаагчид холбогдох хууль эрх зүйн акт, албан тушаалын заавар, эрх, үүрэг, ажлын байрны тодорхойлолттой танилцуулан, албаны баталгаа гаргуулахыг дадлагажих багшид, хүний нөөцийн санд болон хувийн хэрэгт мэдээллийн баяжилт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-т үүрэг болгосугай.

5. Цагдаагийн дэд ахлагч Б.Ёндонтүвшингийн сарын үндсэн цалинг ТТ-7-ийн 1 дүгээр шатлалаар буюу 510107 /таван зуун арван мянга нэг зуун долоо/ төгрөгөөр тогтоож, цолны нэмэгдлийг 25, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг 25 хувиар тооцон бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

6. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 01 сарын 18 өдөр Дугаар Б/10 Дуурсах

Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэн,
ажил хариуцуулах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.6, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.3, мөн журмын 5 дугаар зүйлийн 5.1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2019 оны А/24 дүгээр тушаалаар Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Ц.Анхбаяр нь удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнд оролцох болсонтой холбогдуулан 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс энэ оны 12 дугаар сарын 27-ны өдөр хүртэлх хугацаанд Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Н.Өнөмөнх/-өөр даргын зарим чиг үүргийг түр орлон гүйцэтгүүлсүгэй.

2. Цагдаагийн газрын даргын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод заасан үндсэн зорилтын хүрээнд хийгдэх ажлуудыг Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Н.Өнөмөнх/-д хариуцуулсугай.

3.Дээрх чиг үүргүүдийг хэрэгжүүлэн мэдээ, тайланг гаргаж танилцуулан ажиллахыг Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Н.Өнөмөнх/-д үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190025

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**

# ТУШААЛ

2019 оны 01 сарын 18 өдөр Дугаар Б/17 Дуурсах

Н.Өнөмөнх, Б.Мөнгөнтулга нарт сахилгын шийтгэл оногдуулах тухай

Монгол Улсын төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.2 дахь хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.2, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246, 248 дугаар тушаалуудаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Байгууллагын даргын тушаал гаргах" /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г", "Сахилгын шийтгэл ногдуулах" /код 914/-ын 914.3.3, 914.3.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын дэд даргаас 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 3/07 дугаартай үүрэг, ажлын чиглэлийн дагуу Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалаар батлагдсан "Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм"-ийн 13 дугаар зүйлийн 13.11, 13.17 дахь хэсэгт заасныг зөрчсөн Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Найманжингийн Өнөмөнх, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч Бадраагийн Мөнгөнтулга нарт албан тушаалын сарын үндсэн цалинг 2/хоёр/ сар 20 /хорь/ хувь бууруулах сахилгын шийтгэл оногдуулсугай.

2. Цагдаагийн хошууч Н.Өнөмөнх, Б.Мөнгөнтулга нарт дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг, хариуцсан алба хаагчтайгаа ажиллах ажиллагаа өдөр тутамд тавих хяналтаа сайжруулж, алба хаагчдынхаа сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зааварчилгаа өгч ажиллахыг Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Н.Өнөмөнх/, сэтгэл зүйн чиглэлээр ярилцлага, судалгааг явуулан дүгнэлт хийн танилцуулахыг сэтгэл зүйч /дадлагажих ажилтан Н.Оюунбилэг/-т тус тус үүрэг болгосугай.



20190033

3. Цагдаагийн хошууч Н.Өнөмөнх, Б.Мөнгөнтулга нарын хувийн хэрэг болон хүний нөөцийн санд баяжилт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн, /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-т үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 01 сарын 21 өдөр Дугаар Б/12 Дуурсах

Т.Рэнцэнбадамыг албанаас чөлөөлж, цол хураах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4, Засгийн газрын 2017 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цагдаагийн бага, дунд, ахлах цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх журам"-ын 5.2.4 Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх" журам /код 900/-ын 900.3.4-ийн "б", "Албанаас чөлөөлөх, халах" журам /код 911/-ын 911.2.2, 911.3.1 "б", 911.5.1, 911.5.2, 911.5.3, "Алба хаагчид албаны үнэмлэх, энгэрийн тэмдэг олгох, хураан авах" /код 916/-ын 916.4.2, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дах хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ар гэрийн хачигдлын улмаас өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан Шуурхай удирдлагын тасгийн мэдээлэл хүлээн авагч, жижүүрийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Туяагийн Рэнцэнбадамыг энэ оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлж, цагдаагийн дэд ахлагч цолыг хураасугай.

2. Т.Рэнцэнбадамтай ээлжийн амралтын тооцоог Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын дагуу тооцож олгох, үнэт цаас, бусад холбогдох тооцоог хийж дуусгахыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/, нягтлан бодогч, /цагдаагийн дэслэгч Б.Даваацэрэн/ нарт, албаны үнэмлэх, энгэрийн тэмдгийн тооцоо хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-т, дүрэмт хувцасны тооцоо хийхийг аж ахуйн ажилтан /цагдаагийн дэслэгч Б.Пүрэвсүрэн/, нярав, цагдаагийн дэд ахлагч Н.Элбэгсайхан нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 01 сарын 21 өдөр Дугаар Б/13 Дуурсах

Дадлагажуулагч багш томилон
цалин тогтоох тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох” журам /код 924/, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох” журам /код 944/-ын 944.5, 944.6.4, “Байгууллагын даргын тушаал гаргах” /код136/-ын136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”, Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2019 оны Б/02 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2019 оны Б/02 дугаар тушаалаар Захиргааны удирдлагын тасгийн цагдаа жолоочийн албан тушаал /ажлын байр/-д томилогдсон цагдаагийн дэд ахлагч Оюунбилэгийн Хонгор, Өлзиймөнхийн Хадбаатар, нарын дадлагажуулагч багшаар аж ахуйн ажилтан, /цагдаагийн дэслэгч Б.Пүрэвсүрэн/ нярав цагдаагийн албан тушаал /ажлын байр/-д томилогдсон цагдаагийн дэд ахлагч Норовсамбуугийн Элбэгсайханы дадлагажуулагч багшаар ахлах нягтлан бодогч, /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн цагдаагийн албан тушаал /ажлын байр/-д томилогдсон цагдаагийн дэд ахлагч Эхбаярын Балжинням, Шүүхийн хамгаалалтын цагдаагийн албан тушаал /ажлын байр/-д томилогдсон цагдаагийн дэд ахлагч Эрдэнэбаатарын Базарсад нарын дадлагажуулагч багшаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэв журмын ажил хариуцсан байцаагч, /цагдаагийн ахлах дэслэгч А.Алтантогоо/ нарыг тус тус томилсугай.

2. Цагдаагийн дэд ахлагч О.Хонгор, Ө.Хадбаатар, Н.Элбэгсайхан, Э.Балжинням, Э.Базарсад нарыг ажил албанд нь богино хугацаанд сургаж, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, мэргэжлийн алдаа дутагдал гаргах, гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, мэргэжлийн чиг баримжаатай

болгох чиглэлээр удирдамж, төлөвлөгөө боловсруулан 6 сарын хугацаанд сурган дадлагажуулж, явц үр дүнгийн талаар илтгэх хуудсаар танилцуулахыг дадлагажуулагч багш нарт даалгасугай.

3. Цагдаагийн дэд ахлагч О.Хонгор, Ө.Хадбаатар, Н.Элбэгсайхан, Э.Балжинням, Э.Базарсад нарт холбогдох хууль эрх зүйн акт, албан тушаалын заавар, эрх, үүрэг, ажлын байрны тодорхойлолттой танилцуулан, албаны баталгаа гаргуулахыг дадлагажуулагч багш нарт, хүний нөөцийн санд болон хувийн хэрэгт мэдээллийн баяжилт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-д тус тус үүрэг болгосугай.

4. Цагдаагийн дэд ахлагч О.Хонгорын албан тушаалын сарын үндсэн цалинг ТТ-07-ын 1 дүгээр шатлалаар буюу 550915 /таван зуун тавин мянга есөн зуун арван тав/ төгрөгөөр тогтоож, цолны нэмэгдлийг 25, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг 25 хувиар, Цагдаагийн дэд ахлагч Ө.Хадбаатарын албан тушаалын сарын үндсэн цалинг ТТ-07-ын 1 дүгээр шатлалаар буюу 550915 /таван зуун тавин мянга есөн зуун арван тав/ төгрөгөөр тогтоож, цолны нэмэгдлийг 25, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг 25 хувиар, Цагдаагийн дэд ахлагч Н.Элбэгсайханы албан тушаалын сарын үндсэн цалинг ТТ-07-ын 1 дүгээр шатлалаар буюу 550915 /таван зуун тавин мянга есөн зуун арван тав/ төгрөгөөр тогтоож, цолны нэмэгдлийг 25, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг 20 хувиар, Цагдаагийн дэд ахлагч Э.Балжиннямын албан тушаалын сарын үндсэн цалинг ТТ-07-ын 1 дүгээр шатлалаар буюу 550915 /таван зуун тавин мянга есөн зуун арван тав/ төгрөгөөр тогтоож, цолны нэмэгдлийг 25, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг 25 хувиар, Цагдаагийн дэд ахлагч Э.Базарсадын албан тушаалын сарын үндсэн цалинг ТТ-07-ын 1 дүгээр шатлалаар буюу 550915 /таван зуун тавин мянга есөн зуун арван тав/ төгрөгөөр тогтоож, цолны нэмэгдлийг 25, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг 25 хувиар тус тус тооцон бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 01 сарын 21 өдөр Дугаар Б/14 Дуурсах

Дадлагын удирдагч багш томилох тухай

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/157 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Цагдаагийн мэргэжлийн сургуулийн сонсогчийн дадлагын сургалт" /код 945/, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код136/-ын136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г", Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хууль сахиулахын их сургуулийн захирлын хамтарсан 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/20, А/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн "Цагдаа-хууль сахиулах ажил" бакалаврын хөтөлбөрийн сургалтын 344, 345, 337 дугаар дамжааны сонсогч Сүхбаатарын Дашбалбар, Баатарсүхийн Батсайхан, Дашбатын Ариунцэцэг нарыг "Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах" чиглэлээр 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл Монхдойн Цэнд-Аюушийн "Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах" чиглэлээр 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс 02 дугаар сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд үйлдвэрлэлийн дадлага тус тус хийлгэсүгэй.

2. Сонсогч С.Дашбалбарын дадлагажуулагч багшаар мөрдөгч, цагдаагийн ахмад Н.Түмэннасан, Б.Батсайханы дадлагажуулагч багшаар мөрдөгч, цагдаагийн ахмад М.Дамдиндорж, Д.Ариунцэцэгийн дадлагажуулагч багшаар мөрдөгч, /цагдаагийн ахмад Г.Гансүх/ М.Цэнд-Аюушийн дадлагажуулагч багшаар мөрдөгч, /цагдаагийн дэслэгч Н.Отгонбаяр/ нарыг тус тус томилсугай.

3. Дадлагын хугацаанд сонсогч С.Дашбалбар, Б.Батсайхан, Д.Ариунцэцэг нарын дадлагын удирдамжинд заасны дагуу сурган дадлагажуулж, хэрхэн ажилласан тухайгаа баримтжуулан ажиллахыг дадлагын удирдагч багш мөрдөгч, /цагдаагийн ахмад М.Дамдиндорж, Г.Гансүх, Н.Түмэннасан/ нарт үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 01 сарын 21 өдөр Дугаар 6/15 Дуурсах

Б.Үзэхбаярын хөдөлмөрийн гэрээг
цуцлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Байгууллагын даргын тушаал гаргах” /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын цагаар ажлын байр нь дээрээ архидан согтуурсан Бямбаагийн Үзэхбаярын хөдөлмөрийн гэрээг 2019 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс цуцалсугай.

2. Б.Үзэхбаярын ажилласан хоногийн цалинг зохих журмын дагуу тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190041

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 01 сарын 21 өдөр Дугаар 6/16 Дуурсах

Н.Түмэнжаргалтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, галчаар түр ажиллуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Байгууллагын даргын тушаал гаргах" /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газарт галчаар ажиллахаар хүсэлт гаргасан Нямдоржийн Түмэнжаргалыг 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн гэрээ байгуулж, галчаар түр ажиллуулсугай.

2. Н.Түмэнжаргалтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/, аж ахуйн ажилтан /цагдаагийн дэслэгч Б.Пүрэвсүрэн/ нарт даалгасугай.

3. Н.Түмэнжаргал цалинг ТҮ-2-ын 1 дүгээр шатлал буюу 452933 /дөрвөн зуун тавин хоёр мянга есөн зуун гучин гурав/ төгрөгөөр тооцож, нэмэлт санхүүжилтээс олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190043

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 01 сарын 21 өдөр Дугаар Б/17 Дуурсах

С.Батааг олон нийтийн цагдаагийн
ажлаас чөлөөлж, хөдөлмөрийн
гэрээг цуцлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар батлагдсан "Олон нийтийн цагдаагийн дүрэм"-ийн 9.3, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өөрийн хүсэлтээр олон нийтийн цагдаагийн ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан Баян-Овоо сумын олон нийтийн цагдаа Сэмбээгийн Батаагийн хөдөлмөрийн гэрээг 2019 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс дуусгавар болгож, ажлаас чөлөөлсүгэй.

2.Олон нийтийн цагдаагаас чөлөөлөгдсөн С.Батаагийн хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, холбооны, нэг бүрийн, хамгаалах хэрэгслийг хураах, эдэлгээний хугацаа дуусаагүй үнийн зөрүүг нөхөн төлүүлж, тооцоо хийж дуусгахыг Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, /цагдаагийн ахмад М.Баянзул/-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр /-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190047

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 01 сарын 24 өдөр Дугаар Б/18 Дуурсах

Олон нийтийн цагдаагаар
томилох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 63.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм”-ийн 2.3, 2.8, 3.1, 3.3, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Олон нийтийн цагдаагаар ажиллах хүсэлт гарган, сонгон шалгаруулалт, сургалтад хамрагдаж тэнцсэн иргэдийг тухайн шатны Засаг даргын саналыг үндэслэн Дэнсмаагийн Мөнх-Эрдэнийг Баян-Өндөр сумын олон нийтийн цагдаагаар, Норовсамбуугийн Дамчойчойгялыг Баян-Овоо сумын олон нийтийн цагдаагаар энэ оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн томилж, хөдөлмөрийн гэрээ тус тус байгуулсугай.

2. Олон нийтийн цагдаа Д.Мөнх-Эрдэнийн дадлагажуулагч багшаар Баян-Өндөр сум дахь хэсгийн төлөөлөгч, /цагдаагийн дэслэгч Л.Дуламдорж/, Н.Дамчойчойгялын дадлагажуулагч багшаар Баян-Овоо сум дахь хэсгийн төлөөлөгч, /цагдаагийн дэслэгч Ө.Тэмүүлэн/ нарыг тус тус томилсугай.

3.Олон нийтийн цагдаагаар шинээр томилогдсон Д.Мөнх-Эрдэнэ, Н.Дамчойчойгял нарын сурган дадлагажуулж ажиллахыг дадлагажуулагч багшид, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн /цагдаагийн ахмад М.Баянзул/, хүний нөөцийн асуудлыг хариуцан ажиллахыг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Шинээр томилогдсон олон нийтийн цагдаа нарт үнэмлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, холбооны, нэг бүрийн, хамгаалах хэрэгслийг тавьж олгохыг Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, /цагдаагийн ахмад М.Баянзул/-д үүрэг болгосугай.

5.Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр /-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190049

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 28 өдөр Дугаар Б/19 Дуурсах

Тангараг өргүүлэх тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 75 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цагдаагийн алба хаагчийн тангараг анх болон давтан өргөх ёслолын журам"-ын 2, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Байгууллагын даргын тушаал гаргах" /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2019 Б/02 дугаар тушаалаар тус газарт шинээр томилогдон ажиллаж байгаа цагдаагийн дэд ахлагч Оюунбилэгийн Хонгор, Өлзиймөнхийн Хадбаатар, Норовсамбуугийн Элбэгсайхан, Эхбаярын Балжинням, Эрдэнэбаатарын Базарсад нараар 2019 оны 02 дугаар сарын 01-ны өдөр "Баасан" гарагийн 11:40 /морь цагт/-т Цагдаагийн газрын жагсаалын талбайд "Цагдаагийн тангараг" өргүүлсүгэй.

2.Тангараг өргөх ёслолын ажиллагааг зохион байгуулах алба хаагчаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн хошууч Б.Мөнгөнтулга/-ыг томилсугай.

3.Ёслолын ажиллагааны удирдамж, төлөвлөгөөг гарган батлуулж, иргэд, олон нийтэд үйл ажиллагаагаа сурталчилж, өндөр түвшинд зохион байгуулахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-т үүрэг болгосугай.

4.Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга / цагдаагийн хошууч С.Ариунбаяр /-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190051